



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/276

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын засвар, шинэчлэлт (Булган сум)-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 299,497,601 (хоёр зуун ерэн есөн сая дөрвөн зуун ерэн долоон мянга зургаан зуун нэг) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.


3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010359

001 дүгээр сарын 2024 оны
Аймгийн Засаг даргын 2024 оны
...-ний өдрийн .../2024 дугаар
захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	4,645,973	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	4,645,973	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,322,987	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	418,138	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	12,000,000	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Ажил гүйцэтгэх хугацаа	35 хоног	Ү.Бямбасүрэн